

### НЭХЭМЖЛЭХ № . . . . .

Нэхэмжлэгч: \_\_\_\_\_ Төлөгч: \_\_\_\_\_  
 Байгууллагын нэр: ӨМӨ - ҮХИИ Байгууллагын нэр: Дигжик  
 \_\_\_\_\_ ХХК \_\_\_\_\_ Төгрөгний санхүүгийн  
 Хаяг: \_\_\_\_\_ Хаяг: \_\_\_\_\_  
 Утас: Факс: \_\_\_\_\_  
 Э\_шуудан \_\_\_\_\_ Гэрээний № \_\_\_\_\_  
 Банкны нэр Анх  
 Банкны дансны дугаар 5194043569 Нэхэмжилсэн огноо 2017-11-03  
 Регистрийн №: 5723825 Төлбөр хийх хугацаа 2017-11-10

№	Гүйлгээний утга	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	<u>Төгрөгний санхүүгийн хүү</u>	1	7,900,000	7,900,000

Дүн	<b>ТӨГРӨГНИЙ САН</b> 437
НОАТ	
Нийт дүн	



Мөнгөний дүн \_\_\_\_\_ (үсгээр) \_\_\_\_\_ болно.  
 Дарга \_\_\_\_\_ /  
 Хүлээн авсан \_\_\_\_\_ /  
 Нягтлан бодогч \_\_\_\_\_ /

## БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ: ФИЗИК, ТЕХНОЛОГИЙН  
ХҮРЭЭЛЭНГ ТӨЛӨӨЛЖ  
ЗАХИРАЛ П.АЛТАНЦОГ



ГҮЙЦЭТГЭГЧ: ӨНӨ-ҮЖИН ХХК-Г  
ТӨЛӨӨЛЖ ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Н.БЯМЬАСҮРЭН



## АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Нэг талаас ШУА-ийн Физик, Технологиийн хүрээлэн (цаашид “Захиалагч гэх”) нөгөө талаас “Өнө-Үжин” ХХК — (цаашид “Ажил гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “Гэрээ” гэх) байгуулав.

### 1. Ерөнхий заалт

1. Энэхүү гэрээ нь Ажил гүйцэтгэгч ШУА-ийн түүний харьяа хүрээлэн төвүүдийн зарим байруудыг холбосон дотоод сүлжээ, түүний найдвартай, тогтвортой, аюулгүй байдлыг хангасан сүлжээг зохион байгуулах нөгөө талаас Захиалагч гэрээнд заасан хугацаанд төлбөр төлөх болон талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна. Энэ гэрээнд зааснаар ажил гүйцэтгэгч нь дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд

- 1.1 Байгууллагын дотоод сүлжээний бүтэц үүсгэж зохион байгуулах
- 1.2 Дэд сүлжээ болон тэдгээрийн хаяглалтыг ажлын байр нэгжээс хамааруулан шинэчлэн зохион байгуулах
- 1.5 Сүлжээний физик холболт кабелийн тэмдэг тэмдэглэгээг хийж сүлжээнд буруу холболт хийхээс сэргийлэх
- 1.6 Босоо болон хэвтээ сувагчлалыг байруудад нэгдсэн журмаар сайжруулж шаардлагатай газруудад шинээр татах
- 1.7 Байруудын зангилааны болон давхарын сүлжээний холболтын төхөөрөмжүүдийг зориулалтын хайрцагт байрлуулан ажлын өрөөнөөс гарган коридорт байрлуулах
- 1.8 Энэхүү гэрээнд зохицуулагдаагүй харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

### 2. Гэрээний хугацаа

- 2.1 Ажил гүйцэтгэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоох бөгөөд календарийн тооллыг удирдлага болгоно.
- 2.2 Ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа ажлын 30 хоног байх бөгөөд гэрээнд заасан төлбөрийг ажил гүйцэтгэгчийн дассанд шилжүүлсэнээр дуусгавар болно.
- 2.3 Ажил эхлэх хугацааг гэрээ байгуулсан өдрөөс эхлэн тооцно.
- 2.4 Ажил дуусах хугацааг гэрээ байгуулсан өдрөөс эхлэн ажлын 14 хоногоор тооцож дуусгавар болгоно.

2.5 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас Ажил гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгэж чадахгүйд хүрвэл Захиалагчид нэн даруй мэдэгдэж Захиалагч нь нэмэлт хугацаа тогтоож өгнө

### 3. Ажлын хөлс

3.1 Гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт хөлс 7,900,000 (Долоон сая есөн зуун мянган) төгрөг байна.

3.2 Ажил эхлэх үед Захиалагч тал ажлын үнийн дүнгийн 50%-ийг ажил гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ.

3.3 Ажил гүйцэтгэгч нь гүйцэтгэвэл зохих нийт ажил үйлчилгээг бүрэн гүйцэтгэж захиалагчид ажлын үр дүнг хүлээлгэн өгч тайлагнах бөгөөд захиалагч ажлын үр дүнг хүлээн авсанаас хойш үлдэгдэл төлбөрийг ажил гүйцэтгэгчийн ХААН банкны 5174043563 тоот дансанд ажлын 3 хоногт багтаан шилжүүлнэ.

### 4. Захиалагчийн эрх, үүрэг

4.1 Ажил гүйцэтгэгчийг ажлын даалгавар болон шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.

4.2 Ажил гүйцэтгэгчдийн гаргасан дотоод сүлжээний зураглалын дагуу кабель монтаж татах ажлыг холбогдох хариуцсан албан тушаалтнуудтай хамтарч ажиллах боломжийг бүрдүүлж өгнө.

4.3 Гүйцэтгэсэн ажлын үр дүнд доголдол байна гэж үзвэл ажил хүлээн авсанаас хойш 3 хоногийн дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.

4.4 Гэрээнд заасан хугацаа болон ажлын үр дүнг хүлээн авмагц ажил үйлчилгээний төлбөрийг төлөх үүрэгтэй.

4.5 Ажил гүйцэтгэгч нь гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгэхийг захиалагч тал шаардана.

### 5. Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг

5.1 Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх үүрэгтэй.

5.2 Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг биечлэн гүйцэтгэх үүрэгтэй.

5.3 Ажил гүйцэтгэх үед ашигласан тоног төхөөрөмжийг ажил дууссаны дараа захиалагчид буцаан хүлээлгэн өгнө.

5.4 Ажил гүйцэтгэхэд шаардагдах аливаа бичиг баримт, мэдээллээр хангагдах эрхтэй.

5.5 Захиалагч ажлын үр дүнг хугацаанд нь авах үүргээ биелүүлээгүй бол ажлын үр дүнг хүлээн авсанд тооцож хөлс төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй.

### 6. Талуудын хүлээх хариуцлага

3.4 Гүйцэтгэгч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 1% хувийн алданги төлнө.

3.5 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

3.6 Торгууль, алданги төлсөн нь материалыг устгасан, гэмтээснийг нөхөн төлөх үүрэг гүйцэтгэхээс чөлөөлөгдөхгүй.

## 7. Давагдашгүй хүчин зүйл

7.1 Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

7.2 Дээрхи давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

## 8. Бусад заалт

8.1 Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. (эсвэл хүчин төгөлдөр болох өдрийг тохиролцож болно)


8.2 Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

8.3 Талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Үндэсний Арбитрт түүний Арбитрын Хэрэг Шийдвэрлэх Дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

## 9. Гэрээ байгуулсан

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Физик, Технологийн Хүрээлэнгийн  
Информатикийн салбарын эрхлэгч

  
/ Д. Ууганбаатар /

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Өнө-Үжин ХХК-ийн захирал

  
/ Н.Бямбасүрэн /